

Евразийн интеграцчлал: Гаалийн холбооноос Евразийн эдийн засгийн холбоонд

А.Нямдолжин*

ОХУ ТУХН-ийн орон зайд Евразийн эдийн засгийн холбоо байгуулах зорилго тавьснаас хойш 20 гаруй жил болж байна. Энэ хугацаанд Евразийн эдийн засгийн нийгэмлэг, Гаалийн холбоо, Нэгдсэн эдийн засгийн орон зай зэрэг интеграцийн бүлэглэлүүд бий болж, улмаар 2015 оноос Евразийн эдийн засгийн холбоо болгон өргөжүүлэхээр төлөвлөж байна. 2014 оны 5-р сарын 29-нд Гаалийн холбооны гурван орны тэргүүнүүд тус холбоог байгуулах тухай гэрээнд гарын үсэг зурсан нь дэлхий нийтийн анхаарлыг татаж байгаа бөгөөд хэрш зэргэлдээ оршдог Монгол Улсын анхаарлыг ч зүй ёсоор татаж байна. Тус өгүүлэлд Евразийн эдийн засгийн интеграцчлалын үе шат болон интеграцийн үйл явцад ОХУ-ын гүйцэтгэж буй үүрэг оролцоог харуулахыг зорьлоо.

20 years have passed since Russia has set a goal to create economic union in the CIS. During this period appeared Eurasian Economic Community, the Customs Union and the Common Economic Space as an integration project. Therefore, an Economic Union is planned to be established by 2015. Three leaders of the Customs Union was signed on 29 May 2014 the Treaty establishing the Eurasian Economic Union, which has attracted worldwide attention and also adjacent Mongolia.

* А.Нямдолжин ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан.

ОЛОН УЛС СУДЛАЛ

This article is devoted to show the stages of Eurasian economic integration and Russian involvement in this integration process.

Түлхүүр үгс: Евразийн эдийн засгийн нийгэмлэг, Гаалийн холбоо, Нэгдсэн эдийн засгийн орон зай, Евразийн эдийн засгийн холбоо

Key words: Eurasian Economic Community, Customs Union, Unified Economic Space, Eurasian Economic Union

* * *



1991 онд ЗХУ задарч, олон тусгаар тогтносон улс бий болж, ОХУ шинээр байгуулагдсаны дараа нэг талаас Баруун Европ, АНУ-тай интеграцчлагдах, нөгөө талаас Орос улс нь Украин, Беларусь, Төв Ази ба Кавказад нөлөөгөө тогтоон Барууныг сөрсөн интеграцлалыг бий болгох гэсэн хоёр ялгаатай үзэл санааны зөрөлдөөнөөс евразийн интеграцлалын асуудал яригдах болсон.

ОХУ хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнуудын эдийн засагт байр сууриа дахин бэхжүүлэх, нөлөөгөө сэргээх геополитик, геоэдийн засгийн бодлогын үүднээс бүс нутгийн интеграцлалын шинэ механизм, шинэ гарцыг эрэлхийлсээр даруй 20 гаруй жил болж байна. Анхны интеграцийн хэлбэр болох ТУХН-ийг 1991 онд байгуулж, 1993 онд Европын Холбоотой адил бүрэн хэмжээний эдийн засгийн холбоо байгуулна гэдгээ зарласан¹. 1992-1994 онд ТУХН-ийн 10 оронтой Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан нь интеграцийн дараагийн шатны эхлэл болж, эдүгээ ОХУ-ын зүгээс тэргүүлэх үүрэгтэй оролцож буй Евразийн эдийн засгийн нийгэмлэг, Гаалийн холбоо, Нэгдсэн эдийн засгийн орон зай зэрэг бүлэглэлүүд бүрэлдэн гишүүн орнуудын хамтын ажиллагааны хүрээнд интеграцлал явагдаж байна. Цаашлаад 2015 онд ТУХН-ийн орон зайд нэгдсэн том зах зээлийг бүрдүүлэх Евразийн эдийн засгийн холбоо болгон өргөжүүлж, Гаалийн холбооны гишүүн орнууд болох Орос, Беларусь, Казахстан шинэчилсэн зарчмын дагуу хамтран ажиллахаар төлөвлөөд байна. Тус холбоо нь гурван улсын үйлдвэрлэл, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлж, цаашид тус орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжилд ахиц авч ирнэ гэж талууд үзэж байна.

1999 оны 2-р сард Беларусь, Казахстан, Киргизстан, Орос, Тажикстан улсууд интеграцлалыг дараах 3 үе шаттай явуулах Гаалийн холбоо болон Нэгдсэн эдийн засгийн орон зай байгуулах тухай хэлэлцээрт² гарын үсэг зурсан. Үүнд:

- Евразийн эдийн засгийн нийгэмлэг
- Гаалийн холбоо
- Нэгдсэн эдийн засгийн орон зай

Евразийн эдийн засгийн нийгэмлэг. Гаалийн холбоо ба Нэгдсэн эдийн засгийн орон зайг байгуулах үйл явцыг түргэтгэх зорилгоор “Евразийн эдийн засгийн нийгэмлэг байгуулах тухай гэрээ”³ -нд (ЕврАзЭС) 2000 оны 10-р сарын 10-ны өдөр Беларусь, Казахстан, Киргизстан, ОХУ, Тажикистаны төрийн тэргүүнүүд гарын үсэг зурж, 2001 оны 5-р сарын 30-наас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.

Евразийн Эдийн засгийн нийгэмлэг (цаашид ЕАЭЗН) нь НҮБ-ын зарчим, олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулдаг олон улсын байгууллага бөгөөд 200

3 онд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн ажиглагчийн статустай болсон байна. Нийгэмлэгийн дүрэмд зааснаар интеграцийн зарчмыг удирдлага болгон 2007-2010 онд Беларусь, Казахстан, Орос гурван орны Гаалийн холбоо байгуулах, интеграцийн дараагийн шатанд 2012 оны 1-р сарын 1-нээс гурван орны Нэгдсэн эдийн засгийн орон зайг байгуулах төлөвлөгөөг гурван орны тэргүүн нар дээрх нийгэмлэгийн улс хоорондын зөвлөлийн хуралдаан дээр баталсан байна.

ЕАЭЗН нь хуучин ЗХУ-ын газар нутгийн 91%, ТУХН-ийн орнуудын хүн амын 64% буюу 182.3 сая хүн амыг хамруулж, дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний 4%⁴, дэлхийн газрын тосны илэрсэн

¹Rilka Dragneva and Kataryna Wolczuk. Russia, the Eurasian Customs Union and the EU: Cooperation, Stagnation or Rivalry?, August 2012, P.3. http://www.chathamhouse.org/sites/files/chathamhouse/public/Research/Russia%20and%20Eurasia/0812bp_dragnevawolczuk.pdf

²Договор от 26 февраля 1999 года о Таможенном союзе и Едином экономическом пространстве. http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_31914/

³ Договор об учреждении Евразийского экономического сообщества. // <http://www.evrazes.com/about/history>

⁴ Евразийское Экономическое сообщество. Справочник. М.2010. Стр. 6.// <http://www.evrazes.com/i/data/item7264-2.pdf>

ОЛОН УЛС СУДЛАЛ

нөөцийн 7.5%, нүүрс, хийн 22%, эрчим хүчний үйлдвэрлэлийн 5.5%, гангийн үйлдвэрийн 5.1%, үр тарианы 5.9% гишүүн орнуудад ногдож байна.⁵ Өнгөрсөн хугацаанд ЕАЭЗН-ийн хүрээнд олон улсын 215, түүний дотор Гаалийн холбооны хүрээнд 96 гэрээ, төрийн болон засгийн газрын тэргүүнүүдийн түвшиний 38 хуралдаан болж, 23 зөвлөл, комисс байгуулагдаж, олон улсын байгууллагуудтай 33 санамж бичигт гарын үсэг зурж, Интеграцийн хорооны 60 хуралдаан, Байнгын төлөөлөгчдийн комиссын 80 хуралдаан болжээ.

2012 оны 12-р сарын 19-нд Москва хотноо болсон ЕАЭЗН-ийн улс хоорондын зөвлөлийн хуралдаан дээр ОХУ-ын Ерөнхийлөгч, ЕАЭЗН-ийн улс хоорондын зөвлөлийн дарга В.Путин: «ЕАЭЗН бол ТУХН-ийн орнуудын орон зайн маш амжилттай интеграцийн нэгдэл гэж хэлэхэд илүүдэхгүй. Нийгэмлэг нь Гаалийн холбоо, Нэгдсэн эдийн засгийн орон зай болон тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах байгууллага болох Евразийн эдийн засгийн комисс байгуулах зэрэг өмнөө тавьсан зорилгоо биелүүллээ. ЕАЭЗН-ийн парламент хоорондын ассамблей ба ЕАЭЗН-ийн Шүүх тогтвортой ажиллаж байна. Гаалийн холбоо, Нэгдсэн эдийн засгийн орон зай, ЕАЭЗН нь Евразийн эдийн засгийн холбоо гэсэн интеграцийн нэг хэлбэрийг бүрдүүлэн нэг чиглэлээр ажиллаж байна. ЕАЭЗН Евразийн эдийн засгийн холбоо бүрэлдэх хүртэл буюу 2015 он хүртэл үйл ажиллагаагаа явуулах болно»⁶ гэж хэлжээ.

Гаалийн холбоо. 1995 онд Гаалийн холбооны тухай анхны хэлэлцээр байгуулснаас хойш 15 жилийн турш хоёр үе шаттайгаар нийт 40 орчим гэрээ, хэлэлцээрийн үр дүнд 2010 оны 1-р сарын 1-нд ОХУ, Беларусь, Казахстаны Гаалийн холбоо байгуулагдав. Гаалийн холбоо нь гишүүн орнуудын худалдаа эдийн засгийн саадыг арилгах, эдийн засгийн хөгжлийн тогтвортой байдлыг хангах, бараа эргэлтийг чөлөөтэй болгох, нэгдсэн эдийн засгийн орон зайг бий болгох, дэлхийн зах зээл дээр гарах нөхцлийг бүрдүүлэхэд оршиж байна. Гишүүн орнуудын гарлын бүтээгдэхүүнд гаалийн татвар, түүнтэй ижил төстэй

⁵ ЕврАзЭС Сегодня 2013. М.2010. Стр.14. // <http://www.evrazes.com/i/data/item7621-1.pdf>

⁶ Заседание межгоссовета ЕврАзЭС. Москва. Кремль. 19 декабря 2012 г. // <http://www.evrazes.com/i/data/item7621-1.pdf>

Гаалийн холбооноос Евразийн эдийн засгийн холбоонд

хураамж, тооны хязгаарлалтыг арилгах, гуравдагч орнуудтай хийх худалдаанд гишүүн орнууд тарифын болон тарифын бус зохицуулалтын нэгдсэн дэглэм тогтоох зарчмыг баримталдаг.

Гаалийн холбоо байгуулагдсан өнгөрсөн гурван жилийн хугацаанд Гаалийн холбоо хэр үр ашигтай нэгдэл болж, гурван орны эдийн засагт хир нөлөөлснийг авч үзье.

Хүснэгт 5.23. Гишүүн орнуудын дотор зарим төрлийн бараанд оногдуулж буй гаалийн тариф.⁷

код	нэр	нэгж	%
0102	Цэвэр үүлдрийн амьд үхэр, хонь, ямаа	ш	0
4101	Боловсруулагүй арьс, шир	ш	0
2603	Хүдэр, зэсийн баяжмал	-	5
2701	Коксжсон нүүрс	-	0
2709	Түүхий нефть	-	0
2710	95-аас дээш октантай бензин	1000л	5
2716	Эрчим хүч	1000 кВт.ц	0

Хүснэгт 5. 24. Гаалийн холбооны орнуудын бараа эргэлт (2010-2013 он)⁸

Он	ГХ мян.ам. долл.	Түүний дотор					
		Беларусь		Казахстан		ОХУ	
		мян. ам.долл.	Эзлэх %	мян. ам.долл.	Эзлэх %	мян. ам.долл.	Эзлэх %
2010	47 134,6	10 418,4	22,1	5 999,2	12,7	30 717,0	65,2
2011	63 100,9	15 182,9	24,1	7 103,3	11,3	40 814,7	64,6
2012	68 582,2	17 090,0	24,9	6 837,8	10,0	44 654,4	66
2013 оны I улирал	52 900,0						62,2

Гаалийн холбооны статистикийн үзүүлэлтээс харахад, 2011

⁷Единый таможенный тариф Таможенного союза. Приложение к решению Совета Евразийской экономической комиссии от 16 июля 2012 № 54. / www.tsouz.ru/

⁸ Итоги взаимной торговли государств - членов ТС и ЕЭП за 2012-2013 гг. /http://www.tsouz.ru/db/stat/iCU201303/Documents/i201303_1.pdf

ОЛОН УЛС СУДЛАЛ

онд гишүүн орнуудын хооронд хийсэн худалдаа 33%-иар өссөн бол 2012 онд 2011 онтой харьцуулахад ердөө 8.7%-ийн өсөлттэй байв. 2013 онд 5.9%-иар буурсан нь Гаалийн холбооны эдийн засаг хямралтай тулгараад байгааг харуулж байна. 2013 онд Казахстаны гишүүн орнуудтай хийсэн худалдаа 3.7%-иар буурсан (Орос-9.4%, Беларусь-12.6%-ийн өсөлттэй) байна. Казахстаны макроэдийн засгийн энэхүү таагүй үзүүлэлтийг дотоодын хуулийн дутуу боловсруулалт, нэгдсэн зах зээл дээрх барааны өрсөлдөх чадвар дутмаг, бусад гишүүн орнуудын тогтоосон хамгаалалтын саадтай холбоотой хэмээн шинжээчид тайлбарлаж байна.

Гаалийн холбооны гишүүн орнууд хоорондын бараа эргэлт буурсан нь экспортод түүхий эдийн бүтээгдэхүүн давамгайлж, түүхий эдийн бус барааны өрсөлдөх чадвар доогуур, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн уналттай холбон тайлбарлаж байна. Гишүүн орнуудын өргөн хэрэглээний бараа болон үйлчилгээний үнэ өсч, худалдан авах чадвар буурч, инфляцийн түвшин өссөн байна.

Гаалийн холбоон дахь Беларусийн өнөөгийн байдал.

Беларусийн хувьд 170 сая хүнтэй хэрэглэгчийн зах зээл нээгдсэн нь нэг талаас сайн талтай ч нөгөө талаас сөрөг үр дагавар авчирч байна. Гаалийн татваргүй болсноор өргөн хэрэглээний бүтээгдэхүүнийг бөөнөөр маш их хэмжээгээр Орос руу экспортлохноор дотоодын эдийн засагт хүчтэй нөлөөлж, Беларусийн зах зээл дээр элсэн чихэр, мах болон бусад бүтээгдэхүүн эрс хомсдоход хүргэсэн байна.

2012 онд ОХУ-ын Беларусьт нийлүүлэх нефтийн бүтээгдэхүүний нийлүүлэлт огцом нэмэгдэж, 2013 онд 30 хүртэл хувиар буурсан зэрэг нийлүүлэлтийн тогтворгүй байдал Гаалийн холбооны нийт бараа эргэлтэнд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болжээ. Беларусьт нефть нийлүүлэлтээ зогсоосноо Оросын тал төмөр замын таваарын вагоны дутагдалтай гэсэн шалтгаанаар тайлбарлаж байна. Харин шинжээчдийн үзэж байгаагаар Беларусь 1993 онд ЕХ-нд элсэх тухай санаачилга гаргаснаас хойш идэвхитэй алхам хийлгүй явж ирсэн бөгөөд 2013 онд ЕХ-нд элсэх “хэлэлцээрийн шаардлагатай баримт бичгийн багцыг” ЕХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газарт

илгээсэнтэй холбоотой ОХУ Беларусьт нийлүүлэх нефтийн экспортын хэмжээгээ бууруулсан байж болох талтай.

Гаалийн холбоон дахь Казахстаны өнөөгийн байдал.

Казахстан нь Орос, Беларусийн нутгаар бүтээгдэхүүнээ үнэгүй тээвэрлэх, Казахстаны нутаг дэвсгэр дээр хамтарсан үйлдвэр байгуулах замаар хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх, Казахстаны үйлдвэрлэгчид Орос, Беларусь гэсэн шинэ зах зээл дээр гарах, бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар нэмэгдэх; хүний нөөцийн урсгал багасч, Казахстан руу мэргэжилтнүүдийг татах зорилгоор Гаалийн холбоонд нэгдсэн.

Казахстан Гаалийн холбоонд бэлтгэлгүй, яаран орсноос нэмүү өртөг шингэсэн үйлдвэрийн бүтээгдэхүүн нь өнөөдөр хамгаалагдаагүй, гадуурхагдан, хохирол амсаж байна. Казахстаны нутаг дэвсгэр дээр Орос, Беларусийн эм давамгайлж байгааг Евразийн эдийн засгийн комисс тайлбарлахдаа, эм нийлүүлэлтийн талаарх нэгдсэн зах зээлийн баримт бичигт гарын үсэг зурах үйл явцад Казахстаны тал удаашралтай хандсан тул хөнгөлөлт эдэлж чадахгүй байгаа юм гэжээ. Казахстан, Беларусийн үйлдвэр, худалдаа эрхлэгчдийн зүгээс Оросын тал зах зээлээ хамгаалахын тулд эрүүл ахуйн, техникийн саад тотгорыг үүсгэж байгаа талаар шүүмжилж байна. Беларусь, Казахстаны Засгийн газар Гаалийн холбоо байгуулсан явдал нь эдийн засгийн гэхээсээ илүү улс төрийн шийдвэр байсан гэж үзэж байна.

Гаалийн холбоон дахь ОХУ-ын өнөөгийн байдал

Гаалийн холбоо нь Орос улсад илүү үр ашигтай байгаа бөгөөд Беларусь, Казахстаны хувьд тэнцвэртэй хөгжлийг хангаж чадахгүй байна. 2012 онд ОХУ нь Гаалийн холбооны худалдааны эргэлтийн 65.1%, 2013 оны эхний 5 сард ОХУ 62.2%-ийг тус тус эзэлж байгаа нь гурван талын хооронд бараа гүйлгээний тэнцвэртэй эргэлтийг хангаж чадахгүйгээс улбаалан Гаалийн холбооны зах зээл нь бүрэн боломжоороо ажиллах нөхцлийг бүрдүүлэхгүй хагас нээлттэй зах зээлийг бий болгож байна. ОХУ-ын хувьд Гаалийн холбооны нутгаар дамжин өнгөрөх тээвэр үнэгүй тул Беларусийн нутгаар дамжуулан Өрнөдийн орнууд руу гаргах нефтийн бүтээгдэхүүнээ тээвэрлэх нь эдийн засгийн ач холбогдолтой. Оросын нефть дамжуулах 5 хоолойн 2

нь Беларусийн нутгаар дамждаг.

Түүнчлэн гурван улсын хил дээр гаалийн хяналтын системгүй болсон нь нууцаар хил давуулан наймаа хийх (контрабанд), хар тамхиний нийлүүлэлт 2013 оны 3-р сарын тайлангаар нэмэгдсэн үзүүлэлттэй гарч, цаашид энэ өсөлт нэмэгдэх хандлагатай байгаагийн дээр Гаалийн холбооны гишүүнчлэл нэмэгдэн, өргөжих тусам контрабандын урсгал улам нэмэгдэх нь зайлшгүй. Тухайн нөхцөл байдлыг гурван улсын хилээр нэвтрэх хяналт шалгалтыг чангатгах замаар шийдвэрлэж болох ч Гаалийн холбооны ерөнхий зарчимд харшилж байгаа юм.

Гаалийн холбооны гишүүн орнуудын гуравдагч орнуудтай хийх худалдааны гаалийн тарифын бодлого ба Монгол

Өнөөгийн байдлаар Гаалийн холбооны гуравдагч улсын бараа, бүтээгдэхүүнд ногдуулж байгаа гаалийн татвар өндөр байна. Нэгдсэн гаалийн тарифын протоколд⁹ зааснаар хөгжиж буй орнуудаас импортлох бараанд 75%-ийн гаалийн татвар ногдуулж, буурай хөгжилтэй орнууд болон ОХУ-тай ЧХХ байгуулсан ТУХН-ийн орнууд, Гүрж, Серби (ОХУ Серби улстай 2010 онд ЧХХ байгуулсан учир хөнгөлттэй болон гаалийн татваргүй нөхцөлөөр бараа гүйлгээ хийдэг) зэрэг орнуудын импортын бараанд ногдуулах татварыг тэглэсэн байна.

Гаалийн Холбооны нэгдсэн тарифын протоколд Монгол Улс хөгжиж буй орнуудын жагсаалтанд багтаж байна.¹⁰ Гаалийн нэгдсэн тарифын гуравдагч орноос нийлүүлэх импортын барааны журмын дагуу манай улсын гол нэрийн экспортын бүтээгдэхүүн болох зэсийн баяжмал - 5%, үхэр, адууны шир, хонь, ямааны арьс - 5%, мах, махан бүтээгдэхүүн 15%, оёмол, сүлжмэл эдлэлд 1 кг тутамд 0.7 еврогоос дээш татвартай байна.¹¹

⁹“Нэгдсэн гаалийн тарифын протокол-ын” дагуу Гаалийн холбооны гишүүн орнууд гуравдагч орнуудыг хөгжиж буй орнууд, буурай хөгжилтэй орнууд гэж хоёр ангилан тэдгээрийн импортод ногдуулах тарифыг тус бүрд нь тогтоож нэгдсэн тарифын журмын дагуу ижил хэмжээний адил татвар авах болсон. <http://www.tsouz.r>

¹⁰Перечень развивающихся стран - пользователей системы тарифных преференций Таможенного союза.// <http://www.tsouz.ru/db/ettr/Pages/RazvivStrani.aspx>

¹¹Единый таможенный тариф Таможенного союза Республики Беларусь, Республики Казахстан и Российской Федерации (ЕТТ ТС) – свод ставок ввозных таможенных пошлин, применяемых к товарам, ввозимым на единую таможенную территорию Таможенного союза из третьих стран. / <http://www.tsouz.ru>

Гаалийн холбооноос Евразийн эдийн засгийн холбоонд

Хүснэгт 5.25. Гаалийн холбооны гадаад худалдаа буюу гуравдагч орнуудтай хийсэн худалдаа (2011-2012 он) (мян.ам.долл.)¹²

Улсууд	2011				2012			
	Нийт эргэлт	экспорт	импорт	Эзлэх %	Нийт эргэлт	экспорт	Импорт	Эзлэх %
ЕХ	468,570,395	325,187,722	143,382,673	51,45	491,123,972	341,871,339	149,252,633	52,28
АНДЭЗХА	230,940,877	115,389,428	115,551,449	25,36	239,933,061	114,205,801	125,727,260	25,54
ТУХН	80,439,176	50,738,584	29,700,591	8,83	78,774,178	50,740,742	28,033,436	8,39
Бусад	127,839,339	92,626,100	35,213,238	14,04	127,860,007	92,264,528	35,595,478	13,61
Түүний дотор Монгол улс	1,139,984	1,609,764	90,130	0,19	2,082,230	2,016,248	65,982	0,22

Хүснэгт 5.26. Гаалийн холбооны гишүүн орнуудын Монгол Улстай хийсэн экспортоос (2012 он)¹³

Код	Барааны нэр	Хэмжээ нэгж	Гаалийн холбоо		Эзлэх хувийн жин %		
			тот	Үнэ. ам.долл.	ОХУ	Казахстан	Беларусь
0407	өндөг	кг	5 695 581	9 161 504	100		
1001	Улаан буудай	кг	40 68 200	1 023 246	100		
1101	гурил	кг	45 133 246	15 075 337	100		
2710	Нефтийн бүтээгдэхүүн		1 210 705 039	1 376 127 696	100		
2716	Эрчим хүч	100квтц	392 750	25 740 254	100		
3102	Азотын бордоо	кг	49 108 929	20 064 068	100		

¹²Итоги внешней торговли Таможенного союза с третьими странами. http://www.tsouz.ru/db/stat/eCU201212/Documents/COUNTRIES201212_1.pdf

¹³Распределение экспорта товаров Таможенного союза по странам за январь-декабрь 2012 года. <http://www.tsouz.ru/db/stat/eCU201212/Documents/ExpTovStr201212.pdf>

ОЛОН УЛС СУДЛАЛ

Хүснэгт 5.27. Гаалийн холбооны гишүүн орнуудын Монгол Улстай хийсэн импортоос (2012)¹⁴

Код	Барааны нэр	Хэмжих нэгж	Гаалийн холбоо		Эзлэх хувийн жин %		
			тоо	Үнэ ам.долл.	ОХУ	Казахстан	Беларусь
0202	Хөлдөөсөн үхрийн мах	кг	916 206	3 199 054	59,5	40,5	
0205	Адууны мах	кг	1 360 167	4 378 073	98,1	1,9	
2529	Хайлуур жонш	кг	246 281 248	54 671 222	100		
2611	Зэс, гянт болдын баяжмал	кг	10 100	131 100	100		
2701	Чулуун нүүрс	кг	2 742 603	112 210	100		
5105	Ноос, ноолуур	кг	17 689	21 758	100		
5702	Хивс, хивсэнцэр	М2	16 355	347 960	41,3	58,7	

Тус статистик үзүүлэлтээс харахад Гаалийн холбооны гуравдагч орнуудтай хийсэн худалдаа эерэг үзүүлэлттэй байгаа бол Монгол Улсын хувьд Гаалийн холбооны гишүүн гурван оронтой хийж буй худалдаа ижил бус, ОХУ дийлэнх хувийг эзэлж байгаа ба худалдаа тэнцвэргүй ихээхэн алдагдалтай байна. Манай улс 400 орчим нэр төрлийн бүтээгдэхүүн импортлож байгаагаас нефтийн бүтээгдэхүүн, эрчим хүч дийлэнх хувийг эзэлж байгаагийн дээр экспортын барааны төрөл цөөн, тоо хэмжээ бага байна. Монгол махны 90 гаруй хувийг ОХУ импортлож, дараагаар нь Япон, Солонгос, Казахстан улс ордог. Монголын компаниуд махыг нэмүү өртөг багатай бүтээгдэхүүн буюу хөлдөөсөн гулууз хэлбэрээр экспортлодог. Бараа тээвэрлэх, хадгалах, боловсруулах өнөөгийн арга хэлбэр импортлогч орнуудын эрүүл ахуйн болон эрүүл мэндийн бусад стандартыг хангахгүй байгаа нь сөргөөр нөлөөлж, эрүүл ахуйн стандартыг хангасан ч гаалийн тариф болон бусад саад тотгор маш их хүндрэл учруулж байна. Олон улсын гэрээнд нийцүүлэн ОХУ 1996 оноос хий, газрын тосноос бусад бүтээгдэхүүний экспортын татварыг халсан¹⁵ боловч эдийн засгаа сайжруулах үүднээс

¹⁴Распределение импорта товаров Таможенного союза по странам за январь-декабрь 2012 года. <http://www.tsouz.ru/db/stat/eCU201212/Documents/ImpTovStr201212.pdf>

¹⁵Постановление правительства Российской Федерации от 1 апреля 1996 г. n 479 об отмене вывозных таможенных пошлин,изменении ставок акциза на нефть и дополнительных мерах по обеспечению поступления доходов в федеральный бюджет./ <http://russia.bestpravo.ru/fed1996/data05/tex19975.htm>

1999 онд мод, өнгөт металл, зэс, никель гэх мэт бүтээгдэхүүнд нөхцөлт татварыг тогтоосон.

Гаалийн холбооны тэлэлт.

Гаалийн холбоонд Киргизстан, Тажикистан, Узбекистан, Армэн зэрэг орон элсэх тухай яригдаж байгаа ба эдгээр орнууд Гаалийн холбоонд цаашлаад Евразийн эдийн засгийн холбоонд элсэх “замын зураг”-т гарын үсэг зурж, интеграцийн энэхүү төсөлд орохоор бэлтгэл ажлууд хийгдэж байна. Тухайлбал, Киргизстан Гаалийн холбооны орнуудаас нэг хүнд ногдох ДНБ-ээр 607 дахин хоцорч байгаа юм. Иймд Киргизстанд Гаалийн холбоонд элсэхэд таатай нөхцлийг бүрдүүлэх үүднээс ОХУ-ын зүгээс 1,2 тэрбум ам.долл. санхүүгийн тусламж үзүүлэхээр болжээ. ОХУ ТУХН-ийн орнуудаас гадагш гадаад хүрээг тэлэх үйл ажиллагааг идэвхижүүлэхэд ихээхэн анхаарч байна. Израиль, Вьетнам, Энэтхэг зэрэг орнуудтай чөлөөт худалдааны бүс байгуулах тухай яригдаж байна.

Нэгдсэн эдийн засгийн орон зай. 2003 оны 9-р сард Орос, Казахстан, Беларусийн төрийн тэргүүнүүд нэгдсэн эдийн засгийн орон зай байгуулах тухай хэлэлцээрт гарын үсэг зурж, үзэл баримтлалыг баталсан байна. 2010 онд Нэгдсэн эдийн засгийн орон зайн эрх зүйн 17 хэлэлцээрт гарын үсэг зурж, 2012 оны 1-р сарын 1-ээс үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна. Нэгдсэн эдийн засгийн орон зай нь гишүүн орнуудын эдийн засгийн хөгжлийн үр ашиг, тогтвортой байдлыг хангах зорилготой.

Евразийн эдийн засгийн холбоо. ОХУ нь Гаалийн холбоо ба Нэгдсэн эдийн засгийн орон зайн дараагийн шатны интеграци болох Евразийн эдийн засгийн холбоог 2015 онд байгуулан, Европын холбоотой дүйцэхүйц жин дарах холбоо болгохыг зорьж байгаа бөгөөд урьдчилан товлосны дагуу 2014 оны 5-р сарын 29-нд Астана хотод Евразийн эдийн засгийн дээд зөвлөлийн ээлжит хуралдаанаар ОХУ, Казахстан, Беларусийн төрийн тэргүүн нар Евразийн эдийн засгийн холбооны тухай гэрээ¹⁶ байгуулсан байна. Евразийн холбоо нь Гаалийн

¹⁶ Договор о Евразийском экономическом союзе. <http://www.economy.gov.ru>

ОЛОН УЛС СУДЛАЛ

хууль, Гаалийн холбоо ба Нэгдсэн эдийн засгийн орон зайн тухай Гэрээний хоёр гол баримт бичигт тулгуурлаж байна. Гаалийн холбоо ба Нэгдсэн эдийн засгийн орон зайг тус Холбоогоор сольж байгаа биш, харин үргэлжлэл нь бөгөөд интеграцийн дараагийн шат юм гэж талууд тайлбарлаж байна.

2025 он гэхэд нефть, хийн нэгдсэн зах зээл байгуулж, макроэдийн засаг, валют, санхүү, монополийн эсрэг нэгдсэн бодлого хэрэгжүүлэхээр тохиролцсон ба сүүлийн үед яригдаад байсан нэгдсэн нэг мөнгөн тэмдэгтэй болох тухай гэрээнд тусгагдаагүй байна. Түүнчлэн гэрээнд импортоос дотоодын зах зээлээ хамгаалах механизмыг тусгасан бөгөөд 6 сар хүртэлх хугацаатай улирлын татвар тогтоож, хамгаалалтын, демпингийн эсрэг, нөхөн төлбөрийн арга хэмжээ авах тухай заажээ.¹⁷

Тус холбоо нь ТУХН-ийн орнууд төдийгүй уламжлалт, ойр дотно харилцаатай явж ирсэн Финлянд, Унгар, Чех, Болгар, Вьетнам, Монгол, Куба, Венесуэл зэрэг орнуудыг багтаан өргөжүүлэх боломж байгаа тухай оросын улс төр судлаач Д.Орлов Нэгдсэн Орос намаас зохион байгуулсан дугуй ширээний ярилцлага дээр дурдсан байна. Энэ нь Евразийн холбоог байгуулах замаар ОХУ социалист системийн үед харилцаатай байсан Зүүн Европ болон бусад орнуудтай эдийн засгийн интеграцийг гүнзгийрүүлэх, тэлэх, дэлхийн эдийн засаг дахь хувийн жингээ нэмэгдүүлэх эдийн засгийн зэрэгцээ геополитикийн ашиг сонирхол оршиж байгааг харуулж байна. Энэ тухай Жорж Мэйсоны Их сургуулийн профессор Марк Катц: «Нэгдсэн Орос намаас зохион байгуулсан дугуй ширээний ярилцлагаас харахад Евразийн холбоо нь хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнуудтай ойртох төдийгүй Финлянд, Унгар, Чех, Болгар, Монгол, Вьетнам, тэр байтугай Куба, Венесуэл зэрэг орнуудыг авч үзэж байгаа нь өнөөгийн нөхцөлд боломжтой мэт харагдахгүй байна. Тухайлбал, Финлянд, Унгар, Чех, Болгар зэрэг орнууд Оростой харилцах харилцаандаа ихээхэн болгоомжтой ханддаг бөгөөд АНУ ба ЕХ-той харилцааг хөгжүүлэхийг илүүд үздэг. Вьетнам Хятадаас илүү болгоомжилж, АНУ-тай харилцах харилцаанд хохирол учруулахгүй тохиолдолд Оростой харилцааг

¹⁷ Меры защиты внутреннего рынка. Статья 48. Договор о Евразийском союзе. Стр.45./ <http://www.economy.gov.ru>

хөгжүүлж болох талтай. Монгол Улсын хувьд Орос түүнийг Хятадаас хамгаалахыг хүсч байгаа ч Евразийн холбоонд нэгдэх нь Хятадтай харилцах харилцааг хүндрүүлэх магадлалтай»¹⁸ гэж бичжээ.

Гаалийн холбоог өргөжүүлэн Евразийн эдийн засгийн Холбоо байгуулах тухай асуудалд Барууны орнууд шүүмжлэлтэй хандсаар ирсэн. Тухайлбал, А.Коухен: “Евразийн Холбоо нь Төв Ази болон Дорнод Европын орнуудын улс төр, эдийн засгийн эрх чөлөөг устгаж, бүс нутаг дахь тогтвортой байдалд аюул занал учруулна. Тэр тусмаа, хөрш зэргэлдээ орнуудын улс төрийн чиглэл, тусгаар тогтнол, бие даасан байдалд нөлөөлж, гишүүн бус хөрш орнуудын эдийн засагт хохирол учруулах магадлалтай”¹⁹ гэжээ.

Дүгнэлт

Гаалийн холбооны гишүүн орнуудын өнөөгийн байдлаас харахад гишүүн орнуудын хооронд багагүй зөрчил оршиж байгаа нь ажиглагдаж байна. Гаалийн холбооны хүрээнд гишүүн орнуудын тэгш хөгжлийг хангаж чадахгүй, харилцан итгэлцэл хангалтгүй байгаа нь ОХУ-ын зүгээс бусад орнууддаа ялгаварлан гадуурхах, дарамт шахалт үзүүлэх тал байгаатай холбоотой. Гаалийн холбооны гишүүн орнуудын инфляц нь тасралтгүй тогтмол өсч байна. Ялангуяа Казахстан, Беларусийн инфляцийн үзүүлэлт өндөр байгаа нь экспортын бүтцэд түүхий эд давамгайлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн цөөн байгаатай холбоотой.

Монгол Улс далайд гарах гарцгүй, хоёр хөршөөс эдийн засгийн хувьд хамааралтай орон. Иймд Монгол Улс хөдөө аж ахуй, мал аж ахуйн үйлдвэрлэлийн харьцангуй давуу талдаа тулгуурлан эдийн засгаа төрөлжүүлэх бодлогын хүрээнд дэлхийн тэргүүлэх хөгжилтэй орнуудын техник, технологи нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтыг татах таатай нөхцлийг бүрдүүлэхийн зэрэгцээ дэлхийн том эдийн засагтай Орос, Хятад хоёр оронтой хөрш зэргэлдээ оршдог газар зүйн давуу байдлаа ашиглан эдгээр орнуудын зах зээлд бараа, үйлчилгээ нийлүүлж

¹⁸Mark Katz. (Professor of Government and Politics at George Mason University). Putin proposes setting up Eurasian Union. // <http://voiceofrussia.com>

¹⁹A. Kohen, “Russia’s Eurasian Union Could Endanger the Neighborhood and U.S. Interests”, The Heritage Foundation: Leadership for America, No.2804. – June 14, 2013

ОЛОН УЛС СУДЛАЛ

орлого олох бүхий л боломжийг ашиглах шаардлага тулгарч байна. Энэ үүднээс Евразийн эдийн засгийн холбоотой хамтын ажиллагааг хөгжүүлэхдээ Израиль, Вьетнамын Евразийн эдийн засгийн холбоотой Чөлөөт худалдааны бүс байгуулж болох тухай ярьж байгаатай адил замаар хамтын ажиллагааг хөгжүүлж болох юм. Монгол Улс Ази-Европыг холбосон хамгийн дөт гүүр болохын хувьд бүх төрлийн транзит тээврийг хөгжүүлэх, байгалийн баялгаа дэлхийн зах зээлд бусад орноос хараат бусаар, хямд зардлаар тээвэрлэн борлуулах тал дээр Евразийн холбоотой харилцан ашигтай хамтран ажиллаж болох боловч тус холбооны бүрэн эрхт гишүүн болох асуудалд хянамгай хандаж, гишүүнээр орохгүй байх нь зүйтэй болов уу. Учир нь манай худалдааны гол түнш орон болох Хятад, гуравдагч хөрш орнууд тухайлбал, АНУ-ын зүгээс хоёр талын харилцаанд болгоомжлолыг үүсгэх магадлалтай.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг тэргүүтэй төлөөлөгчид ОХУ-ын Санкт-Петербург хотноо 2014 оны 5-р сарын 22-24-ний өдрүүдэд болж өнгөрсөн Петербургийн Олон улсын эдийн засгийн чуулга уулзалтад оролцох үеэр Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн сайд А.Улюкаевтай уулзаж, хоёр орны хоорондын эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэхэд чиглэсэн тодорхой асуудлуудаар санал солилцжээ. Уулзалтын үеэр А.Улюкаев Гаалийн холбоотой Монгол Улс чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломж бий талаар мэдэгдсэн бөгөөд ойрын хугацаанд хамтын ажиллагааны дунд хугацааны “замын зураг” боловсруулах талаар тохиролцсон байна.²⁰ ОХУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд И.К.Азизов, Бүгд найрамдах Казахстан улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд К.Кобландин нар Евразийн эдийн засгийн холбоо байгуулах тухай гэрээ байгуулагдсаны дараа 6-р сарын 2-нд хамтарсан хэвлэлийн бага хурал зохион байгуулах үеэр тус холбоонд улс орнууд гишүүн болж орох нь нээлттэй²¹ талаар мэдэгдэл хийсэн нь Монгол Улсыг татан оролцуулах сонирхол байгаа нь харагдаж байна.

²⁰Страны Таможенного союза и Монголия могут подписать соглашение о зоне свободной торговли. / <http://www.finmarket.ru/news/3711339>

²¹http://www.mongolia.mid.ru/press_353.html

Ном зүй

1. Rilka Dragneva and Kataryna Wolczuk. Russia, the Eurasian Customs Union and the EU: Cooperation, Stagnation or Rivalry?, August 2012, P.3, http://www.chathamhouse.org/sites/files/chathamhouse/public/Research/Russia%20and%20Eurasia/0812bp_dragnevawolczuk.pdf
2. Договор от 26 февраля 1999 года о Таможенном союзе и Едином экономическом пространстве. http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_31914/
3. Договор об учреждении Евразийского экономического сообщества. <http://www.evrazes.com/about/history>
4. Евразийское Экономическое сообщество. Справочник. М.2010. Стр. 6.// <http://www.evrazes.com/i/data/item7264-2.pdf>
5. ЕврАзЭС Сегодня 2013. М.2010. Стр.14. // <http://www.evrazes.com/i/data/item7621-1.pdf>
6. Заседание межгоссовета ЕврАзЭС. Москва. Кремль. 19 декабря 2012 г. // <http://www.evrazes.com/i/data/item7621-1.pdf>
7. Единый таможенный тариф Таможенного союза. Приложение к решению Совета Евразийской экономической комиссии от 16 июля 2012 № 54. /www.tsouz.ru/
8. Итоги взаимной торговли государств - членов ТС и ЕЭП за 2012-2013 гг.// http://www.tsouz.ru/db/stat/iCU201303/Documents/i201303_1.pdf
9. “Нэгдсэн гаалийн тарифын протокол-ын” дагуу Гаалийн холбооны гишүүн орнууд гуравдагч орнуудыг хөгжиж буй орнууд, буурай хөгжилтэй орнууд гэж хоёр ангилан тэдгээрийн импортод ногдуулах тарифыг тус бүрд нь тогтоож нэгдсэн тарифын журмын дагуу ижил хэмжээний адил татвар авах болсон. <http://www.tsouz.ru>
10. Перечень развивающихся стран - пользователей системы тарифных преференций Таможенного союза.// <http://www.tsouz.ru/db/ettr/Pages/RazvivStrani.aspx>
11. Единый таможенный тариф Таможенного союза Республики Беларусь, Республики Казахстан и Российской Федерации (ЕТТ ТС) – свод ставок ввозных таможенных пошлин, применяемых

- к товарам, ввозимым на единую таможенную территорию Таможенного союза из третьих стран. <http://www.tsouz.ru>
12. Итоги внешней торговли Таможенного союза с третьими странами. http://www.tsouz.ru/db/stat/eCU201212/Documents/COUNTRIES201212_1.pdf
 13. Распределение экспорта товаров Таможенного союза по странам за январь-декабрь 2012 года. <http://www.tsouz.ru/db/stat/eCU201212/Documents/ExpTovStr201212.pdf>
 14. Распределение импорта товаров Таможенного союза по странам за январь-декабрь 2012 года. <http://www.tsouz.ru/db/stat/eCU201212/Documents/ImpTovStr201212.pdf>
 15. Постановление правительства Российской Федерации от 1 апреля 1996 г. n 479 об отмене вывозных таможенных пошлин, изменении ставок акциза на нефть и дополнительных мерах по обеспечению поступления доходов в федеральный бюджет. <http://russia.bestpravo.ru/fed1996/data05/tex19975.htm>
 16. Договор о Евразийском экономическом союзе. <http://www.economy.gov.ru>
 17. Меры защиты внутреннего рынка. Статья 48. Договор о Евразийском союзе. Стр.45./ <http://www.economy.gov.ru>
 18. Mark Katz. (Professor of Government and Politics at George Mason University). Putin proposes setting up Eurasian Union. // <http://voiceofrussia.com>
 19. A.Kohen, "Russia's Eurasian Union Could Endanger the Neighborhood and U.S. Interests", The Heritage Foundation: Leadership for America, No.2804. – June 14, 2013
 20. Страны Таможенного союза и Монголия могут подписать соглашение о зоне свободной торговли. / <http://www.finmarket.ru/news/3711339>
 21. http://www.mongolia.mid.ru/press_353.html